



## МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 8/126

Улаанбаатар хот

Гэрийн тэжээвэр амьтан нохой,  
муурыг бүртгэлжүүлж туулгалтанд  
хамруулах ажлын удирдамж  
батлуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрийн тэжээвэр амьтан буюу нохой, муур бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал, амьтны эрүүл мэндийн газар /Б.Болдбаатар/-т, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, Нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах ажлын гүйцэтгэл, үр дунд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналт баталгаажуулалтын газар /Б.Батсүх/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Алтансүх/-д даалгасугай.



Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын  
2024 оны 11 дүгээр сарын 15-ний/ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт

## ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАН НОХОЙ, МУУРЫГ БҮРТГЭЛЖҮҮЛЖ, ТУУЛГАЛТАНД ХАМРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

### НЭГ. ЗОРИЛГО

Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлж мал, амьтнаас хүнд дамжин халдвартлах зооноз өвчний эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тархалт, халдварталтыг таслан зогсоох зорилгоор гэрчилгээ олгон, туулгалтанд улирал бүр хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

### ХОЁР. ХУГАЦАА

2.1. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах ажлыг 05 дугаар сарын 1-ээс эхлэн зохион байгуулах

### ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭЛДХҮҮН

Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг, багийн Засаг дарга, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нар, малчид, мал бүхий иргэд, амьтан өмчлөгчтэй хамтран хэрэгжүүлнэ.

### ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар

4.1.1. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга нар орон нутагтаа гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах ажлыг гардан үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4.1.2. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах арга хэмжээг зохион байгуулах тухай аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж гарган, хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах;

4.1.3. Гэрийн тэжээвэр амьтнаар дамжин халдвартладаг шимэгчтэх өвчний халдвартын нөхцөл байдлыг тодорхойлох

4.1.4. Зооноз өвчний тархалт, халдварталтын байдал, нийтийн эрүүл мэндэд үзүүлэх хор, хохирлын талаар судалгаа хийх

4.1.5. Дээрх арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг сум тус бүрээр нарийвчлан гаргаж, зохион байгуулах

4.1.6. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, туулгалтанд хамруулах ажлын тайланг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрийн хамт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор МЭЕГ-т файл болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ

4.2. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг, МЭҮН

4.2.1. Сумын МЭТ-ийн мэргэжилтэн нар урьдчилан сэргийлэх, эмчлэх, тэмцэх арга хэмжээг цахим системд төлөвлөх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нар арга хэмжээний гүйцэтгэлийг цахим системд тухай бүрд нь

шивүүлэх, гүйцэтгэлийг оруулахдаа хавсралт хэсэгт хэрэглэсэн бэлдмэлийн зургийг цувралын хамт хавсаргах

4.2.2. МУ-ЫН МАЛЫН ЭМИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН, ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАСАН, МЭЭСБУЛ-ИЙН СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮНТЭЙ БЭЛДМЭЛИЙГ АШИГЛАХ

4.2.3. Гэрийн тэжээвэр амьтныг мал эмнэлгийн үйлчилгээнд тогтмол хамруулаагүйгээс үүсэх эрсдэл болон гэрийн тэжээвэр амьтнаас хүнд халдвартладаг өвчний хор уршгийг таниулах